



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Залуучуудын хөгжлийн зөвлөлийн
үлгэрчилсэн дүрэм батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэг, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 17-д заасан Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулах, үйл ажиллагааг нь зохион байгуулахад баримталж ажиллах үлгэрчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Яам, агентлагийн дэргэд Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах асуудлыг бүх яамны Төрийн нарийн бичгийн даргад, Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, төрийн өмчит аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын дэргэд ажил мэргэжил, сонирхлын дагуу Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Батдорж/ нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д үүрэг болгосугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
Сайдын 2021 оны 5 дугаар сарын
17-ны өдрийн 17 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрэм нь Залуучуудын хөгжлийн зөвлөлийн (цаашид ЗХЗ гэх) үндсэн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага зохион байгуулалт, хариуцлага тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 ЗХЗ нь тухайн нутаг дэвсгэр, байгууллага дахь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих үүрэг бүхий сайн дурын үүсгэл санаачлагын үндсэн дээр бүрэлдсэн орон тооны бус зөвлөл байна.

1.3 ЗХЗ нь зохион байгуулалт, үйл ажиллагаандаа энэхүү дүрмийг мөрдлөг болгох бөгөөд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөр, холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

1.4 Залуучуудын хөгжлийн зөвлөлийн оноосон нэр:

- 1.4.1 Монгол хэлээр: ".....Залуучуудын Хөгжлийн Зөвлөл"
1.4.2 Англи хэлээр: ".....Youth development council"

Хоёр. Эрхэм зорилго, алсын хараа

2.1 Алсын хараа: Монгол залуу хүн бүрийн "Аз жаргал"-тай амьдралын төлөө

2.2 Эрхэм зорилго: Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд энэхүү зөвлөлийн зорилго оршино.

Гурав. Баримтлах зарчим

3.1 ЗХЗ-ийн гишүүд нь дараах зарчмыг баримтална:

- 3.1.1 Хүний эрх, хуульт ёсыг дээдлэх;
3.1.2 Бусдыг сонсох, ялгаварлан гадуурхахгүй байх;
3.1.3 Ил тод, нээлттэй байх;
3.1.4 Тэгш эрхтэй байх;
3.1.5 Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, эерэг хандлагатай байх;
3.1.6 Залуучуудын санал санаачилга, сайн дурын үйл ажиллагааг дэмжих;

- 3.1.7 Шинийг санаачлагч байх;
- 3.1.8 Идэвхитэй хамтрагч, оролцогч байх;
- 3.1.9 Хариуцлагатай байх, шударга, эх оронч үзэл;
- 3.1.10 Өрсөлдөх чадвараа хөгжүүлэх;

Дөрөв: Үндсэн чиг үүрэг

4.1. ЗХЗ нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

- 4.1.1 Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэхэд иргэд, аж ахуй нэгж байгууллага, төрийн байгууллагуудын уялдааг сайжруулахад төлөвлөгөө гаргаж хамтран ажиллах, хяналт тавих, хэрэгжилтийг хангах;
- 4.1.2 Залуучуудын өмнө тулгамдаж буй аливаа асуудлаар хэлэлцүүлэг, хурал, зөвлөгөөн, чуулганаар хэлэлцэж гарсан санал санаачлагыг уламжлах, төлөөлөх, холбогдох газарт хүргэх;
- 4.1.3 Залуучуудын сайн дурын үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах, сурталчлах;
- 4.1.4 Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, зохион байгуулах;
- 4.1.5 Залуучуудын сонирхлын клуб, дугуйлан, зөвлөл, хамтын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;
- 4.1.6 Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;
- 4.1.7 Зорилтот бүлгийн залуучуудад дэмжлэг үзүүлж ажиллах, санаачлах;

Тав. Бүтэц, зохион байгуулалт

5.1. ЗХЗ нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна.

- 5.1.1 ЗХЗ-ийн эрх барих дээд байгууллага нь Үндэсний чуулган /цаашид Чуулган гэх/ байна.
- 5.1.2 Чуулганыг жил бүр нэг болон нэгээс доогүй удаа зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
- 5.1.3 Чуулганаар ЗХЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнийг сонгох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, тайлан илтгэлийг сонсох, хэлэлцэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.1.4 Баг, хорооны ЗХЗ жилд нэг удаа хуралдаан зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг дараагийн шатны зөвлөлийн чуулганд танилцуулж, оролцоно.

- 5.1.5 Аймаг, нийслэл, дүүргийн ЗХЗ нь жилд нэг удаа чуулган зохион байгуулж, гарсан санал зөвлөмжийг Үндэсний чуулганаар танилцуулж, оролцоно.
- 5.1.6 Аймаг, нийслэлийн Залуучуудын хөгжлийн зөвлөл нь Тэргүүн, дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга, гишүүн, Сум, дүүрэг, баг, хорооны Залуучуудын хөгжлийн зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүнтэй гэсэн бүрэлдэхүүнтэй байна.
- 5.1.7 ЗХЗ-ийн Тэргүүн болон Дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 5.1.7.1 ЗХЗ-ийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг батлах;
- 5.1.7.2 ЗХЗ-ийн хурлыг товлон, хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон хөтөлбөрийг баталж, хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх, доод шатны зөвлөлийг удирдлага, арга зүйгээр хангах;
- 5.1.7.3 ЗХЗ-ийн гишүүдэд ажил үүргийг хуваарилан хариуцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 5.1.7.4 Чуулганы болон хурлын үйл ажиллагаанд ЗХЗ-ийн ажлыг тайлагнах, ЗХЗ-ийг төлөөлөх;
- 5.1.7.5 ЗХЗ-ийн чуулганд Дэд тэргүүн /Дэд дарга/, Ерөнхий нарийн бичгийн даргыг /нарийн бичгийн дарга/ нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг оруулах;
- 5.1.7.6 ЗХЗ-ийн тэргүүн /дарга/ 1 жилээр сонгогдож, 1 удаа улиран сонгогдож болно;
- 5.1.7.7 ЗХЗ-ийн тэргүүн /дарга/ нь Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн гишүүн байх;
- 5.1.8 ЗХЗ-ийн Дэд тэргүүн, Дэд дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 5.1.8.1 ЗХЗ-ийн Дэд тэргүүн /дэд дарга/ 1 жилээр сонгогдож, 1 удаа улиран сонгогдож болно
- 5.1.8.2 Тэргүүн /Дарга/-ийг орлох.
- 5.1.9. ЗХЗ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга /нарийн бичгийн дарга/ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 5.1.9.1 ЗХЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах;
- 5.1.9.2 ЗХЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлуулах, үр дүн, тайлан биелэлтийг Тэргүүнд танилцуулах;
- 5.1.9.3 ЗХЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлуулах, хурал, чуулганы үеэр хурлын тэмдэглэл хөтлөх;
- 5.1.9.4 Архив, албан хэрэг хөтлөх үйл ажиллагааг тогтмол хариуцах;

5.1.9.5 ЗХЗ-ийн хуралдаан, чуулганы бэлтгэл ажлыг хангах, гишүүдийг хурлын тов, хөтөлбөрийн мэдээллээр хангах, хурлаас гарсан шийдвэрийг албажуулах, холбогдох газар хүргүүлэх;

5.1.9.6 ЗХЗ-ийн гишүүдийн ирц, идэвхийг бүртгэх, танилцуулах;

5.1.10 ЗХЗ-ийн Гишүүн нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.1.10.1 ЗХЗ-ийн хурал, чуулганаар хэлэлцэх асуудлаар санал хүргүүлэх;

5.1.10.2 ЗХЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох;

5.1.10.3 Хариуцаж авсан ажлыг гүйцэтгэн тайланг өгөх;

5.1.10.4 ЗХЗ-ийн Тэргүүн /Дарга/, Дэд тэргүүн /Дэд дарга/, Ерөнхий нарийн бичгийн дарга /нарийн бичгийн дарга/-ыг сонгох, чөлөөлөхөд санал өгөх;

5.1.11 ЗХЗ-ийн нийт гишүүд YDC.mn сайтаар бүртгүүлж, цахим батламж авна.

5.1.12 ЗХЗ-ийн гишүүдийн цахим батламжийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас цахимаар олгоно.

5.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороон дахь ЗХЗ

5.2.1. Аймаг, нийслэлийн ЗХЗ нь 25 хүртэлх, сум, дүүргийн ЗХЗ нь 21 хүртэлх, баг, хорооны ЗХЗ нь 11 хүртэлх гишүүнтэй байна.

5.2.2 ЗХЗ нь төрийн болон төрийн бус, аж ахуй нэгж байгууллага, өсвөр үе, оюутан, залуучууд болон зорилтот бүлгийн залуучуудаас бүрдсэн гишүүнчлэлтэй байна.

5.2.3 ЗХЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгоход дараахь төлөөллийг харгалзаж үзнэ. Үүнд:

- Оюутан, залуучуудын төлөөлөл
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын төлөөлөл.
- Төрийн байгууллагад ажилладаг залуучуудын төлөөлөл.
- Бизнесийн салбарт ажилладаг залуучуудын төлөөлөл
- Төрийн бус байгууллагын залуучуудын төлөөлөл
- Эмэгтэй гишүүдийн төлөөлөл нийт гишүүдийн 1/3-ээс багагүй байна.
- Доод шатны Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн байж болно.

5.2.4 ЗХЗ-ийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв арга зүйн удирдлагаар болон зохион байгуулалтаар хангаж ажиллана.

5.2.5 Баг, хорооны ЗХЗ-ийн үйл ажиллагааг сум, дүүргийн ЗХЗ удирдлага, зохион байгуулалтаар хангана.

5.2.6 Сум, дүүргийн ЗХЗ-ийн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн ЗХЗ удирдлага, зохион байгуулалтаар хангана.

5.2.7 Аймаг, нийслэлийн ЗХЗ нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяалагдах Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаатай уялдуулан баталж, 1 дүгээр сарын сүүлийн 7 хоногт багтаан аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлнэ.

5.2.8 Дүүрэг, сум, хороо, багийн ЗХЗ нь үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг дээд шатны ЗХЗ-ийн төлөвлөгөөтэй уялдуулан баталж хүргүүлнэ.

5.2.9 Аймаг, нийслэлийн ЗХЗ нь үйл ажиллагааны тайлан биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, эхний хагас жилийн тайланг 6

- дугаар сарын 15-ны дотор, дараагийн хагас жилийн тайланг 12 дугаар сарын 05-ны дотор тухайн орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлнэ.
- 5.2.10 Тайланг залуучуудын зөвлөлийн тэргүүн, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар баталгаажуулна.
- 5.2.11 Сум, дүүрэг, баг, хорооны ЗХЗ нь тайлан биелэлтээ дээд шатны ЗХЗ-д хүргүүлнэ.
- 5.2.12 ЗХЗ нь жилд нэг удаа тухайн бүс нутгийн хэмжээнд хуралдаан, хэлэлцүүлэг, чуулган зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг дээд шатны зөвлөлд хүргүүлнэ.

5.3. Төрийн байгууллагын дэргэдэх ЗХЗ

- 5.3.1. Төрийн байгууллага дэргэдээ ЗХЗ-тэй байж болно.
- 5.3.2. Төрийн байгууллагын дэргэдэх ЗХЗ нь 25 хүртэлх гишүүнтэй байна.
- 5.3.3 Төрийн байгууллагын дэргэдэх ЗХЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
Үүнд:
- Удирдах албан тушаалтан 1-3 хүн
 - Залуу ажилтан, албан хаагчдын төлөөлөл нийт гишүүдийн 2/3-оос багагүй байна.
 - Эмэгтэй гишүүдийн төлөөлөл нийт гишүүдийн 1/3-ээс багагүй байна.
 - Бусад
- 5.3.4 Төрийн байгууллагын дэргэдэх ЗХЗ нь байгуулагдсан тухай хурлын тэмдэглэл, шийдвэр, бүрэлдэхүүний танилцуулгыг тухайн байгууллагын удирдлага болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж, YDC.mn сайтад бүртгүүлнэ.
- 5.3.5 Төрийн байгууллагын дэргэдэх ЗХЗ-д Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас цахим батламж хүргүүлснээр үүсгэн байгуулагдсанд тооцно.
- 5.3.6 ЗХЗ-ийн үйл ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангана. Цахим батламж

5.4. Аж ахуй нэгж байгууллагуудын дэргэдэх ЗХЗ

- 5.4.1 Аж ахуй нэгж байгууллагууд дэргэдээ ЗХЗ-тэй байж болно.
- 5.4.2 Аж ахуй нэгж байгууллагын дэргэдэх ЗХЗ нь 25 хүртэлх гишүүнтэй байна.
- 5.4.3 ЗХЗ-ийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангана.
- 5.4.4 Аж ахуй нэгж байгууллагын дэргэдэх ЗХЗ нь байгуулагдсан тухай хурлын тэмдэглэл, шийдвэр, бүрэлдэхүүний танилцуулгыг байгууллагын удирдлага болон тухайн орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст бичгээр хүргүүлж, YDC.mn сайтад бүртгүүлнэ.

- 5.4.5 Аж ахуй нэгж байгууллагын дэргэдэх ЗХЗ-д Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас цахим батламж хүргүүлснээр үүсгэн байгуулагдсанд тооцно.

5.5. Мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ

- 5.5.1 Залуучууд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ байгуулж болно.
- 5.5.2 Мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ нь 25 хүртэлх гишүүнтэй байна.
- 5.5.3 Мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ-ийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангана.
- 5.5.4 Мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ нь байгуулагдсан тухай хурлын тэмдэглэл, шийдвэр, бүрэлдэхүүний танилцуулгыг тухайн орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст хүргүүлж, YDC.mn сайтад бүртгүүлнэ.
- 5.5.5 Мэргэжлийн болон сонирхлын ЗХЗ-д ЗХЗ-д Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас цахим батламж хүргүүлснээр үүсгэн байгуулагдсанд тооцно.

Зургаа. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үүрэг, хариуцлага

- 6.1 ЗХЗ нь залуучуудын эрх, хөгжил, оролцоог хангахтай холбоотой асуудлаар санал, санаачилга гаргаж, тухайн бүс нутаг, салбар дахь бодлого, хөтөлбөрт залуучуудын хөгжих орчин нөхцөл, аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тусгуулахад санал гаргах, хэрэгжилтийг дэмжих, хяналт тавих;
- 6.2 Тухайн бүс нутаг, салбар дахь залуучуудад тулгамдсан асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг залуучуудын оролцоотой тодорхойлох, залуучуудаа сонсох, төлөөлөх;
- 6.3 Залуучууд хөгжлийн үндсэний болон салбар зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулах;
- 6.4 Тухайн орон нутаг болон салбарт хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар хэлэлцэх, санал зөвлөмж гаргах, холбогдох байгууллагуудад өргөн барих;
- 6.5 Зөвлөл нь шат шатныхаа зөвлөлөөс жил бүр тайлан нэгтгэлийг гаргаж тайлагнана.
- 6.6 ЗХЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын байгууллагын өгсөн хандив, тусламж, санхүүгийн дэмжлэгийг төлөөлөх эрх бүхий сонгуульт албан тушаалтнууд нь өөрийн дансаар болон өөр этгээдийн дансаар хүлээн авч зарцуулахыг хориглоно.
- 6.7 ЗХЗ нь гишүүдээс сайн дурын үндсэн дээр гишүүнчлэлийн татвар, хураамж авч болно. Хэмжээг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж гишүүдийнхээ олонхиор санал хурааж батална.

Долоо. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

- 7.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд улс төрийн нам, эвсэл, шашны үйл ажиллагааг сурталчлах;
- 7.2. Аливаа байгууллагын болон хувь хүний нэр хүндэд халдах, гүтгэх, гутаан доромжлохыг;
- 7.3. Ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулахгүй байх;

---oOo---